



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/22

Ховд

Хөрөнгө олж бэлтгэх зөвшөөрөл
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 41 дүгээр зүйлийн 41.2.5, 41.2.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хэрэгцээнд ХОА1 байнгын ажиллагаатай станцын эх хавтан, барилгын бетоны бат бэхийг үл эвдэх аргаар тодорхойлох автомат алх /шмидийн алх/ худалдан авахад зориулан орон нутагт эрх шилжсэн барилга угсралтын ажлын захиалагчийн техник хяналтын зардлаас 20 500 000 төгрөг /хорин сая таван зуун мянга/-ийг зарцуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т зөвшөөрсүгэй.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 20 500 000 төгрөг /хорин сая таван зуун мянга/-ийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Төрийн сангийн нэмэлт дансанд шилжүүлж, гүйлгээ хийхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д даалгасугай.

3. Хөрөнгийг харьцуулалтын аргаар худалдан авч, хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлд тусгаж орлого болгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 0132
D/Zah-A/22-Bo